



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРГААНД

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

**ЗАВХАН АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**

212800 Улаастай, Завхан аймаг  
Утас/факс: 7046-37-02  
[www.inspection.gov.mn](http://www.inspection.gov.mn)

2017. 12.07 № 07-07-027/190.

Барилгын төлөв байдлын тухай.

Завхан аймаг дахь Политехник колледжийн захиргаанаас аймгийн МХГ-т гаргасан хүсэлтийг үндэслэн Улаастай сумын Богдын гол багийн нутаг дэвсгэрт байршилтай тус сургуулийн Оюутны байрын барилгын төлөв байдал, "Барилгын тухай хууль"-ийн хэрэгжилтэд Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Ж.Цэдэн-Иш Оюутны байрын багш Б.Оюунчимэг болон холбогдох хүмүүсийг байлцуулан 2017 оны 12-р сарын 06-ний өдөр шалгалт хийлээ. Уг барилгыг мэргэжлийн бус байгууллага хүмүүс сургуулийн дотуур байрын зориулалтаар барьж 1964 онд ашиглалтад орсон, барилгыг улсын комиссоор хүлээн авсан акт болон холбогдох бичиг баримт ашиглагч байгууллагад байхгүй, ашиглалтад орсон үеэс хойш барилгын үндсэн хийцүүдэд их засвар хийгдээгүй. Барилгын үндсэн хийцүүд: суурь-чулуу, хана-дүнз, хучилт-модон бамбай, дээвэр- төмөр байна..

Шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ.

- Барилга батлагдсан зураг төсөлгүй, газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээ төлөвлөгдөөгүй баригдсан, барилгын төмөр дээвэрт их засвар хийгдээгүйгээс ус тусгаарлах чадваргүй болж бороо цасныус дотогш нэвчиж өрөөнүүдийн тааз, ханын шохой, эмульс норж шарласан, зарим хэсэгт хөндийрсөн, хуурсан, дотор цахилгааны монтажид гэмтэл үүссэн, өрөөнүүдийн банзан шал өмхөрсөн, модон хучилт бамбайнууд өмхөрч даацын чадвараа алдан цөмрөх, нурах аюултай болсон, барилгын хойд талын даацын дүнзэн хананд 2-3 үед өмхрөлт үүссэн, дээврийн ус зайлуулах бетон хаявч зарим хэсэгт хагарсан, шороонд дарагдсан, барилгын 1-р давхар өвлийн улиралд их хүйтэн, дулааны алдагдал ихтэй, дотор халаалтын шугам хоолой, халаах хэрэгслүүд бүрэн халдаггүй бөглөрсөн, шугам хоолойнуудаас ус гоождог, резинээр ороосон, барилгын гадна өнгө үзэмж алдагдсан зэрэг нөхцөл байдлууд тогтоогдоо.

Дээрхи байдлуудаас үндэслэн ДҮГНЭХ нь:

1. Политехник колледжийн Оюутны байрын барилгад үүссэн эвдрэл гэмтлүүд

болов барилгын одоогийн төлөв байдал нь "барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх, тогтвортой байх" гэсэн "Барилгын тухай хууль"-ийн 11-р зүйлийн 11.1.1 заалтын болон "Барилга байгууламжийн засвар, ашиглалтын хугацааны жишиг норм" БНБД13-04-03-ын 2.4, 2.5 заалтын шаардлага хангахгүй байна.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХУУЛИЙН  
УЛСЫН БАЙЦААГЧ



Ж.ЦЭДЭН-ИШ